2025 оны 3-р сарын 12

МАНСУУРУУЛАХ БОДИС ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ ХЯЗГААРЛАЛТ ТОГТООСОН ИРГЭДЭД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Сонгинохайрхан дүүргийн прокурорын газраас “шүүхээс мансууруулах бодис хэрэглэхийг хориглох хязгаарлалт тогтоосон” иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, болон холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтын талаар сургалт зохион байгууллаа.

Сургалтаар тус дүүргийн прокурорын газрын ахлах прокурор П.Бямбасүрэн ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналт, албадлагын арга хэмжээний тухай ойлголт, хууль эрх зүйн зохицуулалт, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд үүсэх үр дагаврын талаар, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч А.Энхбаяр хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийн талаар тус тус мэдээлэл өгч, ярилцлага хийжээ.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн шийдвэр гүйцэтгэгч нартай хамтран шүүхээс мансууруулах бодис хэрэглэхийг хориглох хязгаарлалт тогтоосон шийдвэрийн хэрэгжилтийг шалгаж, холбогдох арга

хэмжээг авч ажиллаж байна.

Эх сурвалж: https://songinokhairkhan.prosecutor.mn/post/3400